



ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ИВЭЭЛ ДОР

**INWES-APNN-ICWSTEM**

**АЗИ НОМХОН ДАЛАЙН БҮС НУТГИЙН ГИШҮҮН УЛС  
ОРНУУДЫН ЧУУЛГА-УУЛЗАЛТ  
ОЛОН УЛСЫН ЭМЭГТЭЙ ЭРДЭМТДИЙН ХУРАЛ**



2023 ОНЫ 6-Р САРЫН 29-ӨӨС 7-Р САРЫН 1

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН НОМЫН САН



**APNN 2023  
SDG - WOMEN  
PARTICIPATION**

## **ХУРЛЫН ТАНИЛЦУУЛГА:**

Монголын эмэгтэй эрдэмтэд, инженерүүд, технологичид, математикчдын нэгдсэн байгууллага (WSTEM) нь 2023 оны 6-р сарын 29-өөс 7-р сарын 1-ний өдрүүдэд Ази номхон далайн бүс нутгийн гишүүн улс орнуудын 13 дах удаагийн уулзалт-хурал (INWES-APNN)-ыг Олон улсын эмэгтэй эрдэмтэд инженерүүдийн эрдэм шинжилгээний хурал (ICWSTEM)-тай хамт Ерөнхийлөгчийн ивээл дор “Тогтвортой хөгжилд эмэгтэйчүүдийн оролцоо” сэдвийн хүрээнд зохион байгуулна.

## **ХУРЛЫН ЗОРИЛГО:**

INWES-APNN уулзалт чуулга болон ICWSTEM олон улсын хурал нь эрдэмтэд, инженерүүдийн бүтээлийг таниулах, инновацыг нэвтрүүлэх, туршлага солилцох, хамтын ажиллагааг хөгжүүлэх, судалгаа шинжилгээний өгөөжийг нэмэгдүүлэх, соёл, түүх, уламжлалыг олон улсад таниулах зорилготой.

## **САЛБАР ХУРАЛДААНУУД:**

Дэлхийн тогтвортой хөгжлийн 17 зорилтуудын хүрээнд дараах салбар хуралдааныг зохион байгуулж хуралдаан тус бүрээс шилдэг бүтээлүүдийг шалгаруулна. Үүнд:

- 1) Хүнсний аюулгүй байдал ба эрүүл мэнд (1. Ядуурлыг устгах, 2. Өлсгөлөнг зогсоох, 3. Эрүүл мэндийг дэмжих)
- 2) Боловсрол, шинжлэх ухаан (4. Чанартай боловсролыг дэмжих, 5. Жендерийн эрх, тэгш байдлыг хангах)
- 3) Хүрээлэн буй орчин (6. Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах, 11. Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих, 13. Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах, 14. Далай, тэнгисийн нөөцийг хамгаалах, 15. Хуурай газрын эко системийг хамгаалах)
- 4) Нийгэм, эдийн засаг (8. Эдийн засгийн өсөлт, баталгаат ажлын байрыг бий болгох, 10. Тэгш бус байдлыг бууруулах, 12. Хариуцлагатай хэрэглээг дэмжих, 16. Энх тайван, шударга ёсыг цогцлоох, 17. Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх)
- 5) Инженерчлэл: (7. Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх, 9. Инновац болон дэд бүтцийг нэмэгдүүлэх)

## **ХҮЛЭЭГДЭЖ БАЙГАА ҮР ДҮН:**

Дэлхийн тогтвортой хөгжлийн 17 зорилтуудыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах, эрдэмтэд, инженерүүдийн үйл ажиллагааны хүрээг өргөтгөх, бүтээл инновацыг нийтэд таниулах, тулгамдаж байгаа асуудлуудын гарц, шийдлийг олохоос гадна монголын эмэгтэй эрдэмтэд, инженерүүд төдийгүй Монгол улсын нэр хүндийг өргөх, эх орноо сурталчлахад ихээхэн чухал ач холдогдолтой. Энэ удаагийн INWES-APNN-ICWSTEM олон улсын хуралд 23 гаруй орны 50 гаруй эмэгтэй эрдэмтэд, инженерүүдийн төлөөлөл хүрэлцэн ирэхээр төлөвлөгдөж байна.

Хурлын хүрээнд гарах үр дүнг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

- 1) Эрдэмтэд, инженерүүд, инновац бүтээгчдийн гаргасан санаа, санал, санаачилгыг эмхэтгэн төр захиргааны холбогдох байгууллагуудад хүргэнэ.
- 2) Шилдэг технологи, инновацын бүтээгдэхүүнийг сурталчилна.
- 3) Салбар хуралдаан тус бүрийн эмэгтэй эрдэмтэд, инженерүүдийн шилдэг бүтээлийг түгээн дэлгэрүүлнэ.
- 4) Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл хэвлэгдэнэ.
- 5) Монголын соёл, түүх, уламжлалыг олон улсад сурталчилна.
- 6) Гадаад, дотоодын инженерүүд, эрдэмтдийн харилцаа холбоо, хамтын ажиллагааг хөгжүүлнэ.

## **ЭШ-НИЙ ӨГҮҮЛЭЛ АВАХ:**

Олон улсын хурал нь шинжлэх ухаан, технологи, инновацыг хөгжүүлэх, судлаачид, үйлдвэрлэгчдийн хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилготой тул судалгааны ажлын шинэ үр дүнг харуулсан өгүүлэл ирүүлэхийг урьж байна.

Хураангуй нь 500-аас ихгүй үгтэй, англи ба монгол хэл дээр байна. Өгүүлэл нь англи эсвэл монгол хэл дээр байна. Хуралд бүртгүүлсний дараа өгүүллээ өөрийнхөө хурлын хаягаас илгээнэ. Зөвшөөрөгдсөн өгүүлэл нь хуралд аман эсвэл ханан илтгэл хэлбэрээр тавигдана.

Өгүүлэл бичих загвар болон шаардлагыг хурлын цахим хуудаснаас авна.

## **АНХААРАХ ӨДРҮҮД:**

4-р сарын 1-нд бүртгэл хаагдана.

4-р сарын 15-ийг хүртэл өгүүлэл авна.

5-р сарын 1-нд хариу мэдэгдэнэ.

## **АНХААРАХ ӨДРҮҮД:**

Гишүүд бол

Эрт (3-р сарын 1-ээс өмнө): 100000 төг

Энгийн (3-р сарын 1-ээс хойш): 200000 төг

Гишүүн биш бол

Эрт (3-р сарын 1-ээс өмнө): 200000 төг

Энгийн (3-р сарын 1-ээс хойш): 250000 төг


**ХУРЛЫН ВЕБСАЙТ:**



<https://wstemtraining.web.app/mn/index.html>

**ХУРЛЫН БАЙРШИЛ:**

Монгол улсын их сургуулийн Номын сан (<https://catalog.num.edu.mn>)



## АМТРАН АЖИЛЛАХ БОЛОМЖУУД

*Нэг. Ерөнхий ивээн тэтгэгч*

*20 сая төгрөг*

- 1) Ивээн тэтгэгчийн нэр, логог хурлын анонс дээр байрлуулах
- 2) Байгууллагын төлөөлөл, удирдлагыг хуралд урин оролцуулан хүндэтгэлийн зоог барих
- 3) Хурлын тухай ТВ нэвтрүүлэг, мэдээ бүрд ерөнхий ивээн тэтгэгчийн нэрийг дурдах
- 4) Эрдэм шинжилгээний хурлын арга хэмжээнд ивээн тэтгэгч байгууллагын төлөөллийг урьж оролцуулах, танилцуулгыг нийтэд түгээх
- 5) Байгууллагын танилцуулгыг WSTEM-ийн вэбсайт [www.wstem.mn](http://www.wstem.mn) дээр байрлуулах, олон улсад цахим хуудсаараа дамжуулан таниулах
- 6) Байгууллагын шилдэг эмэгтэй судлаач эсвэл инженерийг БНСУ-д бүрэн тэтгэлгээр эмэгтэй эрдэмтэд, инженерүүдийн хуралд оролцуулах
- 7) Сургалтад үнэгүй болон хөнгөлттэй үнээр хамруулах
- 8) Ивээн тэтгэгчийн эрэлт хэрэгцээнд үндэслэн богино хугацааны сургалт семинарыг зохион байгуулах.

*Хоёр. Ивээн тэтгэгч*

*15 сая төгрөг*

- 1) Ивээн тэтгэгчийн нэр, логог хурлын анонс дээр байрлуулах
- 2) Байгууллагын төлөөлөл, удирдлагыг хуралд урин оролцуулан хүндэтгэлийн зоог барих
- 3) Хурлын тухай ТВ нэвтрүүлэг, мэдээ бүрд ерөнхий ивээн тэтгэгчийн нэрийг дурдах
- 4) Тус эрдэм шинжилгээний хурлын арга хэмжээнд ивээн тэтгэгч байгууллагын төлөөллийг урьж оролцуулах, танилцуулгыг нийтэд түгээх
- 5) Байгууллагын танилцуулгыг WSTEM-ийн вэбсайт [www.wstem.mn](http://www.wstem.mn) дээр байрлуулах, олон улсад цахим хуудсаараа дамжуулан таниулах
- 6) Байгууллагын шилдэг эмэгтэй судлаач эсвэл инженерийг БНСУ-д бүрэн тэтгэлгээр эмэгтэй эрдэмтэд, инженерүүдийн хуралд оролцуулах
- 7) Сургалтад үнэгүй болон хөнгөлттэй үнээр хамруулах.

*Гурав. Хамтран зохион байгуулагч*

*10 сая төгрөг/түүнтэй дүйцэх дэмжлэг*

- 1) Ивээн тэтгэгчийн нэр, логог хурлын анонс дээр байрлуулах, танилцуулгыг оролцогчдод тараах
- 2) Байгууллагын төлөөлөл, удирдлагыг хуралд урин оролцуулан хүндэтгэлийн зоог барих
- 3) Хурлын талаарх ТВ нэвтрүүлэг, мэдээ мэдээлэл бүрд байгууллагын нэрийг дурдах
- 4) Тус эрдэм шинжилгээний хурлын арга хэмжээнд ивээн тэтгэгч байгууллагын төлөөллийг урьж оролцуулах, танилцуулгыг нийтэд хүртээх
- 5) Сургалтад үнэгүй болон хөнгөлттэй үнээр хамруулах.
- 6) Байгууллагын танилцуулгыг WSTEM-ийн вэбсайт [www.wstem.mn](http://www.wstem.mn) дээр байрлуулах, олон улсад цахим хуудсаараа дамжуулан таниулах.

*Дөрөв. Мэдээллийн ивээн тэтгэгч*

*Арга хэмжээг сурталчлах, мэдээлэх*

- 1) Ивээн тэтгэгчийн нэр, логоны хурлын анонс дээр байрлуулах, танилцуулгыг оролцогчдод тараах
- 2) Байгууллагын төлөөлөл, удирдлагыг хуралд урин оролцуулан хүндэтгэлийн зоог барих
- 3) Хурлын талаарх ТВ нэвтрүүлэг, мэдээ мэдээлэл бүрд байгууллагын нэрийг дурдах
- 4) Тус эрдэм шинжилгээний хурлын арга хэмжээнд ивээн тэтгэгч байгууллагын төлөөллийг урьж оролцуулах, танилцуулгыг нийтэд хүртээх
- 5) Байгууллагын танилцуулгыг WSTEM-ийн вэбсайт [www.wstem.mn](http://www.wstem.mn) дээр байрлуулах, олон улсад цахим хуудсаараа дамжуулан таниулах

*Тав. Бусад бүх төрлийн хандив*



**APNN 2023**  
**SDG - WOMEN**  
**PARTICIPATION**



# ХӨТӨЛБӨР

**АЗИ НОМХОН ДАЛАЙН БҮС НУТГИЙН ГИШҮҮН УЛС ОРНУУДЫН УУЛЗАЛТ-ХУРАЛ  
ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН НЭГДСЭН ХӨТӨЛБӨР  
(INWES-APNN-ICWSTEM)**

**ХУРЛЫН ЭХНИЙ ӨДӨР: 2023 оны 6-р сарын 29-ний өдөр (Пүрэв гариг)**  
**Олон улсын эрдэм шинжилгээний хурал**

**Үдээс өмнө:**

Нээлт  
Мэндчилгээ  
Урилгын илтгэгчид  
Цайны завсарлага  
Үндсэн илтгэлүүд

**Өдрийн зоог ба нэтворкинг**

**Үдээс хойш:**

Салбар хуралдаанууд  
Цайны завсарлага  
Салбар хуралдаанууд

**Орой:**

Хүндэтгэлийн хүлээн авалт

**ХУРЛЫН ХОЁРДОХ ӨДӨР: 2023 оны 6-р сарын 30-ны өдөр (Баасан гариг)**  
**Ази номхон далайн бүс нутгийн гишүүн улс орнуудын  
уулзалт хурал**

**Үдээс өмнө:**

Нээлт  
Мэндчилгээ  
Үндсэн илтгэгчид  
Цайны завсарлага  
Ази номхон далайн бүсийн гишүүн орнуудын тайлан

**Өдрийн зоог ба нэтворкинг**

**Үдээс хойш:**

Ази номхон далайн бүсийн гишүүн орнуудын тайлан  
Цайны завсарлага  
Ази номхон далайн бүсийн гишүүн орнуудын тайлан  
Гишүүн орнуудын төлөөлөгчдийн уулзалт

**Орой:**

Түмэн эх чуулган үндэсний концерт (Зөвхөн гадаадын зочдод)

**ХУРЛЫН ГУРАВДАХ ӨДӨР: 2023 оны 07-р сарын 01-ний өдөр  
(Бямба гариг): АЯЛАЛ ЗУГААЛГА**

Олон орнуудын төлөөлөгчтэй уулзаж мэргэжлийн болон эмэгтэйчүүдийн байгууллагын зүгээс холбоо тогтоох, хамтын үйл ажиллагааг эхлүүлэх боломжтой тул та бүхнийг оролцохыг урьж байна.

Энэ аялал зугаалганы төлбөр нь хурлын үндсэн төлбөрт ороогүй тул оролцох бол 13-р зуун цогцолборын тухайн үеийн үнийг төлнө.



**SUSTAINABLE  
DEVELOPMENT GOALS**



**APNN 2023**  
**SDG - WOMEN**  
**PARTICIPATION**



# ХӨТӨЛБӨР

2023 оны 06-р сарын 29-ний өдөр

**ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ (ICWSTEM)**

(Хурлын хөтлөгч Монгол хэл дээр явагдах ба Англи хэлний синхрон орчуулгатай)

**08:00 – 08:30 Хурлын бүртгэл**

**08:30 – 08:45 Нээлтийн үйл ажиллагаа**

- Морин хуур
- Хурлын дарга, доктор Ж.Туяацэцэг

**08:45 – 09:20 Хүндэтгэлийн мэндчилгээ**

- Монгол улсын ерөнхийлөгч (батлагдах)
- Монгол улсын их хурлын гишүүн, доктор Ч.Ундрам (батлагдах)
- Монгол улсын засгийн газрын гишүүн, Боловсрол шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан (батлагдах)
- Монгол улсын их сургуулийн захирал, доктор Б.Очирхуяг
- Олон улсын эмэгтэй эрдэмтэд инженерүүдийн нэгдсэн байгууллагын ерөнхийлөгч, доктор Жанг, Сан Ким

**09:20 – 10:20 Хүндэтгэлийн илтгэлүүд**

- Олон улсын эмэгтэй эрдэмтэд инженерүүдийн нэгдсэн байгууллагын ерөнхийлөгч, доктор Жанг, Сан Ким
- 2011-2017 оны олон улсын эмэгтэй эрдэмтэд инженерүүдийн нэгдсэн байгууллагын дэд ерөнхийлөгч, доктор Марлене Канга

**10:20 – 11:00 ЦАЙНЫ ЗАВСАРЛАГА, ДУРСГАЛЫН ЗУРАГ**

**11:00 – 13:00 Салбар хуралдаанууд**

- Эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал: Доктор Г.Баясгалан, доктор Ж.Туяацэцэг
- Боловсрол, шинжлэх ухаан: Доктор Батцэнгэл, доктор Т. Амаржаргалан
- Хүрээлэн буй орчин: Доктор Д. Буянтогтох, доктор Д.Оюун
- Нийгэм, эдийн засаг: Доктор Н. Сувдаа, доктор Г.Цэрэн
- Инженерчлэл: Доктор П.Ариунболор

**13:00 – 14:00 Өдрийн зоог (Exhibitions and Poster Session)**

**14:00 – 15:40 Салбар хуралдаанууд (үргэлжлэл)**

**15:40 – 16:00 ЦАЙНЫ ЗАВСАРЛАГА**

**16:00 – 18:00 Салбар хуралдаанууд (үргэлжлэл)**

**19:00 – 22:00 Хүндэтгэлийн хүлээн авалт, концерт (батлагдах)**



**APNN 2023**  
**SDG - WOMEN**  
**PARTICIPATION**



# ХӨТӨЛБӨР

2023 оны 06-р сарын 30-ны өдөр

**АЗИ НОМХОН ДАЛАЙН БҮС НУТГИЙН ГИШҮҮН УЛС ОРНУУДЫН УУЛЗАЛТ-ХУРАЛ**  
**(INWES-APNN)**

**07:30 – 08:00** **Хурлын бүртгэл**

**08:00 – 08:05** **Нээлтийн үг:**

Олон улсын эмэгтэй эрдэмтэд инженерүүдийн нэгдсэн байгууллагын удирдах зөвлөлийн гишүүн, доктор **Б.Батцэнгэл**

**08:05 – 08:15** **Хүндэтгэлийн мэндчилгээ**

- Олон улсын эмэгтэй эрдэмтэд инженерүүдийн нэгдсэн байгууллагын ерөнхийлөгч, доктор **Жанг, Сан Ким**
- Олон улсын эмэгтэй эрдэмтэд инженерүүдийн нэгдсэн байгууллагын Ази номхон далайн бүс орнуудын зохицуулагч **Доктор П.Ариунболор**

**08:15 – 09:15** **Зочин илтгэгчид**

- Олон улсын эмэгтэй эрдэмтэд инженерүүдийн нэгдсэн байгууллагын төслийн менежер, доктор **Сарах Пеерс**
- Олон улсын эмэгтэй эрдэмтэд инженерүүдийн нэгдсэн байгууллагын санхүү хариуцсан мэргэжилтэн **Силвия С. Керел**

**09:15 – 09:40**

**ЦАЙНЫ ЗАВСАРЛАГА, ДУРСГАЛЫН ЗУРАГ АВАЛТ**

**09:40 – 12:40**

**Гишүүн орнуудын тайлан (тус бүр 15 минут)**

1. Австрали
2. Солонгос
3. Япон
4. Тайван
5. Вьетнам
6. Филиппин
7. Мьянмар
8. Шриланк
9. Сингапур
10. Энэтхэг
11. Пакистан
12. Шинэ Зеланд

**12:40 – 14:00**

**ӨДРИЙН ХООЛ, ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДАА**

**14:00 – 15:15**

**Гишүүн орнуудын тайлан (тус бүр 15 минут)**

13. Непаль
14. Малайз
15. Бангладеш
16. Индонез
17. Монгол

**15:15 – 15:45**

**ЦАЙНЫ ЗАВСАРЛАГА, ДУРСГАЛЫН ЗУРАГ АВАЛТ**

**15:45 – 16:45**


**Гишүүн улсуудын уулзалт, шинэ гишүүн орнуудын танилцуулга**

**16:45 – 17:15**

**Оройн зоог**

**17:15 – 21:00**


**Түмэн эх чуулга үндэсний концерт**





**APNN 2023**  
**SDG - WOMEN**  
**PARTICIPATION**

Монголын эмэгтэй эрдэмтэд, инженерүүд, технологичид, математикчдын нэгдсэн байгууллага (WSTEM) нь 2023 оны 6-р сарын 29-өөс 7-р сарын 1-ний өдрүүдэд Ази номхон далайн бүс нутгийн гишүүн улс орнуудын 13 дахь удаагийн уулзалт-хурал (INWES-APNN)-ыг Олон улсын эмэгтэй эрдэмтэд инженерүүдийн эрдэм шинжилгээний хурал (ICWSTEM)-тай хамт Ерөнхийлөгчийн ивээл дор “Тогтвортой хөгжилд эмэгтэйчүүдийн оролцоо” сэдвийн хүрээнд зохион байгуулна.



**Тогтвортой хөгжилд  
эмэгтэйчүүдийн  
оролцоо**

## Салбар хуралдаанууд

### 1) Хүнсний аюулгүй байдал ба эрүүл мэнд:

1.Ядуурлыг устгах, 2.Өлсгөлөнг зогсоох, 3. Эрүүл мэндийг дэмжих

### 2) Боловсрол, шинжлэх ухаан:

4.Чанартай боловсролыг дэмжих,  
5.Жендерийн эрх, тэгш байдлыг хангах

### 3) Хүрээлэн буй орчин:

6.Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах, 11.Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих, 13.Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах, 14.Далай, тэнгисийн нөөцийг хамгаалах, 15.Хуурай газрын эко системийг хамгаалах

### 4) Нийгэм, эдийн засаг:

8.Эдийн засгийн өсөлт, баталгаат ажлын байрыг бий болгох, 10.Тэгш бус байдлыг бууруулах, 12.Хариуцлагатай хэрэглээг дэмжих, 16.Энх тайван, шударга ёсыг цогцлоох, 17.Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх

### 5) Инженерчлэл:

7.Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх,  
9.Инновац болон дэд бүтцийг нэмэгдүүлэх

## ЭШ-ний өгүүлэл авах

- Олон улсын хурал нь шинжлэх ухаан, технологи, инновацийг хөгжүүлэх, судлаачид, үйлдвэрлэгчдийн хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилготой тул судалгааны ажлын **шинэ үр дүнг** харуулсан өгүүлэл ирүүлэхийг урьж байна.
- **Хураангуй** нь 500-аас ихгүй үгтэй, англи ба монгол хэл дээр байна
- **Өгүүлэл** нь англи эсвэл монгол хэл дээр байна.
- Хуралд бүртгүүлсний дараа өгүүлээ өөрийнхөө **хурлын хаягаас** илгээнэ.
- Зөвшөөрөгдсөн өгүүлэл нь хуралд аман эсвэл ханан илтгэл хэлбэрээр тавигдана.
- Өгүүлэл бичих загвар болон шаардлагыг **хурлын цахим хуудаснаас** авна.

## Анхаарах өдрүүд

4-р сарын 15-ийг хүртэл өгүүлэл авна.  
5-р сарын 1-нд хариу мэдэгдэнэ.


## Бүртгэлийн хураамж

Гишүүд бол

Эрт (3-р сарын 1-ээс өмнө): 10000 төг  
Энгийн (3-р сарын 1-ээс хойш): 20000 төг

Гишүүн биш бол

Эрт (3-р сарын 1-ээс өмнө): 20000 төг  
Энгийн (3-р сарын 1-ээс хойш): 25000 төг



Монгол улсын их сургуулийн  
Номын санд хуралдана.

Утас: +976- 99015671

Эмэйл: [wstemmongolia@gmail.com](mailto:wstemmongolia@gmail.com)